

**МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО ХК
2023 ОНЫ ЖИЛИЙН ТАЙЛАН**

<i>2023 оны жилийн үйл ажиллагааны тайлагнал /маягт 1/</i>				
<i>Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.</i>				
<i>Тайлагнах хугацаа</i>	2023 оны 01-р сарын 01-ний өдрөөс 2023 оны 12-р сарын 31-ны өдөр			
<i>Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар</i>	“Монголын цахилгаан холбоо” ХК УБГД:000000376 Үнэт цаасны код:209 15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Энхтайваны өргөн чөлөө 1, Утас:7010 2248			
<i>Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр</i>	“Монголын хөрөнгийн бирж” ХК			
<i>Бизнесийн үйл ажиллагааны салбар</i>	Харилцаа холбоо, мэдээлэл технологийн салбар			
<i>Жилийн эцсийн санхүүгийн тайланд аудитын дүгнэлт гаргасан СЗХ-нд бүртгэлтэй аудитын компанийн нэр, бүртгүүлсэн огноо</i>	“Ихмонгол хөлөг Аудит” ХХК			
<i>Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг</i>	25,870,276			
<i>2023 оны жилийн тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр</i>	Бэлтгэсэн: Х.Цэцэгмаа, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Т.Бямбасүрэн, БТА-ны ерөнхий менежер Хянасан: Ж.Баасандорж, Инновац бизнес хөгжлийн газрын захирал			
<i>1.</i>	<i>2023 оны жилийн санхүүгийн тайлан /хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/</i>			
		Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
		ХӨРӨНГӨ		
		Эргэлтийн хөрөнгө	9,373,600,760.26	13,809,299,922.52
		Эргэлтийн бус хөрөнгө	39,666,462,263.24	54,206,606,900.44
		НИЙТ ХӨРӨНГӨ	49,040,063,023.50	68,015,906,822.96
		ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
		Богино хугацаат өр төлбөр	8,001,020,843.91	10,564,343,151.21
		Урт хугацаат өр төлбөр	4,370,849,753.20	7,083,823,446.52
		Эзэмшигчдийн өмч	36,668,192,426.39	50,367,740,225.23
		ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	49,040,063,023.50	68,015,906,822.96
		Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
	<i>Орлогын тайлан</i>	Борлуулалтын орлого /цэвэр/	17,394,684,301.17	18,938,223,103.01
		Борлуулалтын өртөг	(14,343,851,233.06)	(14,704,824,592.67)

		Нийт ашиг (алдагдал)	3,050,833,068.11	4,233,398,510.34
		Түрээсийн орлого	704,504,002.98	649,693,435.66
		Хүүгийн орлого	149,125,182.48	164,718,433.72
		Бусад орлого	487,292,708.78	514,144,459.22
		Борлуулалт, маркетингийн зардал	(1,153,577,454.91)	(1,448,188,458.72)
		Ерөнхий ба удирдлагын зардал	(2,624,476,664.75)	(2,979,884,438.96)
		Санхүүгийн зардал	(96,295,888.11)	(225,432,665.67)
		Бусад зардал	(561,743,958.54)	(869,065,134.37)
		Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	15,362,389.45	(1,994,038.18)
		Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	63,090,908.27	78,681,818.18
		Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	34,114,293.76	116,071,921.22
		Орлогын татварын зардал	(23,414,254.79)	(87,214,478.89)
		Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	10,700,038.97	28,857,442.33
		Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
	<i>Өмчийн өөрчлөлтийн тайлан</i>	Өмч	2,587,027,589.00	2,587,027,589.00
		Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	5,247,555,045.10	14,088,188,462.23
		Эздийн өмчийн бусад хэсэг	8,247,270,172.39	8,247,270,172.39
		Хуримтлагдсан ашиг	20,586,339,619.90	25,445,254,001.61
		Нийт дүн	36,668,192,426.39	50,367,740,225.23
		Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
	<i>Мөнгөн гүйлгээний тайлан</i>	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	6,298,726,072.54	1,410,625,413.20
		Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(6,974,488,200.00)	(966,928,837.96)
		Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(3,501.31)	77,743.00
		Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(675,765,628.77)	443,774,318.24
		Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	983,774,286.87	308,008,601.51
		Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	308,008,601.51	751,782,919.75
<i>1.1</i>	<i>Жилийн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт</i>			
	Аудитлагдсан санхүүгийн тайланд хязгаарлалттай дүгнэлт өгсөн.			
<i>1.2.</i>	<i>Аудитын тодорхойлох захидал</i>			

2024.03.25 № 07/834

Хэвлэвэлтэй санал дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1. Я дугаар зүйлийн 6.1 Төрийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.9.8-д заасны дагуу Монголын цахилгаан холбоо ХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдөрхөт санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй өмчийн өөрчлөлт, өмчийн гүйцэтгэлийн тайлан, тодруулгуудад аудит үйлдээ

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь шөмч чанарын хувьд материаллаг боловч өргөн тархалтай гэм үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөтэй эс тусгаар Монголын цахилгаан холбоо ХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдөрхөт санхүүгийн үзлийн Нэгдсэн бодох бүртгэлийн тухай зууль. Санхүүгийн тайлангийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв төлүүлсэн байна

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхэд Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журмыг заарсан дагуу гүйцэтгэж, аудит хийхэд байгууллагаас хэрвэл бүх аудиторын өс зүйл үүрэг хариуцлагыг биелүүлж амжилсан. Бүтцийн цахилгааны хангалттай бөгөөд хохирол судалгаа нотлогдож нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Нийт илрүүлсэн зөрчил нь бодино тогтоосон материаллаг байдлын түвшингээс 15,678.9 сая төгрөгөөс давсан нь Нэгдсэн бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 12 дугаар зүйлийн 13.1, 4 дугаар зүйлийн 14.4, 14.4.2, 20 дугаар зүйлийн 20.2.4, 20.2.5, 20.2.6 Төрийн бодох орчин нутгийн өмчийн тухай хуулийн 11 зүйлийн 11.6 Нийслэлийн даргаар тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1-д заасантай тус тус нийцээгүй санхүүгийн тайлангийн нэгдсэн бодох хохирол байх зөвлөхөд мэдэгдэж амьдралтай байна. Түүнд

- Ахлах ажилчин үндэслэл: тооцоо хийхэд аргаар баталгаажуулаагүй 11,577.8 сая төгрөг
- Ажлын шалтгаан бүртгэл дутуу 4,113.8 сая төгрөг
- Орлогын нөхөн сууриар бүртгэн тайлагнасан 121.2 сая төгрөг
- Цалин мэдэгдэжээний хэсэг түүнтэй адилтгах орлогыг зарцуулаагүй бүртгэн тайлагнасан 72.4 сая төгрөг
- Ашиглан байгаа бараа материал бодон үндсэн харьцангуй нөхтөл бодох бүртгэлд бүртгээгүй 0.9 сая төгрөг

0801051914

Санхүүгийн тайланг залуулан эсвэл элдэвхэн улмаас үүсэн материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэм үзсэн дотоод хяналтын тодорхойлох хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээжээ

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залуулан эсвэл элдэвхэн улмаас үүсэн материаллаг буруу илэрхийлэлээс санхүүгийн тайланг бэлтгэхэд өмч эсвэл төлөөлөгчид үндэслэлтэй баталгаажуулалт олж авах дүгнэлт зөвлөхөд бүтцийн аудитын тайланг гаргах өөрчлөлтэй

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшинд болон үнэмлэхүй түвшинд баталгаажуулалт байх бөгөөд АДСУО-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бурагд илрүүлж гэмээ баталгаа болсонгүй юм

Буруу илэрхийлэл нь хяналтын эсвэл элдэвхэн улмаас болж бөгөөд дансанд эсвэл нийлээд үл санхүүгийн тайланд үндэслэл гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлж үндэслэлтэй байхад материаллаг гэм үзсэн

САНХҮҮ НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
[Signature] Ц.НАРАМЧИХ

Асуудлыг өчилсөн хэсэг

Монголын цахилгаан холбоо ХК-ийн нийт 25,670,276 ширхэг эдийн зүйлийнх 94.7 хувь буюу 24,466,267 ширхэг зүйлээс Монгол Улсын Засгийн газар 5.3 хувь буюу 370,990 ширхэг зүйлийг 4005 гаднаа дотоодын иргэд хуулийн этгээд зэмлэжээ нээлттэй зууцаахт хяналтын бөгөөд 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдөрхөт байдалд хэсэг зүйлсийн хяналтын хэсэг 4611 ширхэг хэсэг зүйлийн өмчлөгч 11,928.8 сая төгрөг байна

Монгол Улсын Засгийн газрын Төрийн мэдээний хуульд 2022-2023 онд бичрээс өмч нийтэд нээлттэй хуудалд төрийн өмчтэй хуулийн этгээдийн хэсэгт багтж тухай 2022 оны 244 дүгээр тогтоолоор Монголын цахилгаан холбоо ХК-ийн 36 дүгээр зүйлийн өмч нийтэд нээлттэй хуудалд хэрэгжүүлжээ. 2023 оны 382 дугаар тогтоолоор хуудалын өмчлөгчид 2023 оны 4 дүгээр үйлдэлд эзэмсэн байгууллагууд өөрчлөлт оруулсан байна

Санхүүгийн эзэлхүүнээр хэрэгсэл. Нэмж гаргах бүх үнэт цаасны нийтэд санал болгож зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэлд бүртгэл тухай 2024 оны 44 дүгээр тогтоолоор нийтэд санал болгон хэрэгжүүлж буй 11,249,855 ширхэг зүйлээс тогтоосон үнэм аргаас тус бүрийг нь 500 тивэн зуу төгрөгөөр нийтэд санал болгон элдэвхэн зөвшөөрлийг олгожээ

Монголын цахилгаан холбоо ХК-ийн Төлөөлөгч удирдах зөвлөлийн 2023 оны 185 дугаар зурлын тогтоолын 1-д 2022 оны цаасны үнэ болж 10.7 сая төгрөгөөс нэгдэл үнэ хуваарилгаанд хэрэгжүүлжээ 349-г

Аудитын гол асуудал

Төлөөлөгч удирдах зөвлөлийн 2023 оны 182 дугаар тогтоолын 4-т Монголын цахилгаан холбоо ХК-ийн үндсэн харьцангуй бүртгэлтэй Чингэлтэй дүүргийн 1 дугаар хороо Жигшээдэвхэн гууламанд байрлалтай 178 микротайлбайт аргын улсын бүртгэлийн Э-2202005542 дугаартай 4,627.3 сая төгрөгийн хэсэг зүйлийн үнэ бүхий газрыг Мэдээлэл хөдөөгийн сүлжээ ХХК-д төлөх болж хуудалд өр төлбөр тооцон хяналтуулах тогтоолыг баталсан байна

Бусад асуудлын хэсэг







Монголын цахилгаан холбоо ХК-ийн Төлөөлөгч удирдах зөвлөлийн 2023 оны 186 дугаар тогтоолын 1-т компанийн 2022 оны үйл ажиллагааны тайланг хяналттай санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүдийг сайжруулах шаардлагатай гэж дүгнэжээ байна


Компани нь 2023 онд 30 үндсэн аргын үнэ 100 хэмжээтэй хэрэгжүүлжээ 277 арга хэмжээг төлөвлөж буй үйл ажиллагааны тайланд өгөх Төлөөлөгч удирдах зөвлөлийн дүгнэлт бодон хэсэгд гаргажээ байна

Удирдлага бодон Засаглал эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд үзвэл үүрэг хариуцлага


Удирдлага нь санхүүгийн тайланг Нэгдсэн бодох бүртгэлийн тухай хууль Санхүүгийн тайлангийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бүтцийн төлүүлжээ үзвэлтэй

2.	Үнэт цаас гаргагч нь тайлант хугацаанд санхүүгийн нөхцөл байдал, үйл ажиллагааны үр дүнд нөлөөлсөн хүчин зүйлс, удирдлагаас өгсөн үнэлгээ, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар товч тайлбарласан тайлан, мэдээлэл								
2.1.	<table border="1"> <tr> <td data-bbox="335 1993 734 2105">Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/</td> <td data-bbox="734 1993 1149 2105"> <table border="1"> <tr> <td data-bbox="734 1993 1149 2038">Үзүүлэлт</td> <td data-bbox="1149 1993 1404 2038">2022.Q4</td> <td data-bbox="1404 1993 1500 2038">2023.Q4</td> </tr> <tr> <td data-bbox="734 2038 1149 2105">Нийт ашгийн хувь</td> <td data-bbox="1149 2038 1404 2105">18%</td> <td data-bbox="1404 2038 1500 2105">22%</td> </tr> </table> </td> </tr> </table>	Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/	<table border="1"> <tr> <td data-bbox="734 1993 1149 2038">Үзүүлэлт</td> <td data-bbox="1149 1993 1404 2038">2022.Q4</td> <td data-bbox="1404 1993 1500 2038">2023.Q4</td> </tr> <tr> <td data-bbox="734 2038 1149 2105">Нийт ашгийн хувь</td> <td data-bbox="1149 2038 1404 2105">18%</td> <td data-bbox="1404 2038 1500 2105">22%</td> </tr> </table>	Үзүүлэлт	2022.Q4	2023.Q4	Нийт ашгийн хувь	18%	22%
Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/	<table border="1"> <tr> <td data-bbox="734 1993 1149 2038">Үзүүлэлт</td> <td data-bbox="1149 1993 1404 2038">2022.Q4</td> <td data-bbox="1404 1993 1500 2038">2023.Q4</td> </tr> <tr> <td data-bbox="734 2038 1149 2105">Нийт ашгийн хувь</td> <td data-bbox="1149 2038 1404 2105">18%</td> <td data-bbox="1404 2038 1500 2105">22%</td> </tr> </table>	Үзүүлэлт	2022.Q4	2023.Q4	Нийт ашгийн хувь	18%	22%		
Үзүүлэлт	2022.Q4	2023.Q4							
Нийт ашгийн хувь	18%	22%							

		Цэвэр ашгийн хувь	0.1%	0.2%
		Нийт хөрөнгийн өгөөж ROA	0.0002	0.0004
		Өөрийн хөрөнгийн өгөөж ROE	0.0003	0.0006
2.2.	<i>Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт</i>	Үзүүлэлт	2022.Q4	2023.Q4
		Эргэлтийн харьцаа	1.17	1.31
		Төлбөр түргэн гүйцэтгэх харьцаа	0.23	0.17
		Өр төлбөр болон өөрийн хөрөнгө харьцаа	0.34	0.35
2.3.	<i>Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчны нөлөөлөл, бүтээгдэхүүн, үйлчилгээний төрөл хэлбэрт гарч буй өөрчлөлт, дээрх өөрчлөлтөд компанийн зүгээс авч хэрэгжүүлж буй арга хэмжээний мэдээлэл</i>	<p>Нэг. Бизнес өргөжүүлэх</p> <p> 1. KDDI сантай хамтран Хөвсгөл нуурын байгалийн цогцолборт газрын Хүзүүвчийн шил, Жанхай даваа орчмын аялал жуулчлалын бүсэд өндөр хурдын интернэтийн үйлчилгээг хүргэх магистраль сүлжээ байгууллаа.</p> <p> 2. ХУРДАН төрийн үйлчилгээний цэгийг 7 цэгт нээж, цаашид компанийн бүх салбар нэгжээр дамжуулан төрийн цахим үйлчилгээг операторын горимоор үзүүлж байна.</p> <p> 3. БШУЯамтай хамтран боловсрол, сургалтын байгууллагын хичээлийн болон дотуур байранд утасгүй дотоод сүлжээний орчин бүрдүүлэх төсөл хэрэгжүүлж нийслэл, орон төрийн өмчит 262 сургуулийн 712 хичээлийн, дотуур байр болон МСҮТ-ийн байранд дотоод сүлжээг байгуулан ажиллаж байна.</p> <p> 4. Цахим Хөгжил, Харилцаа Холбооны Яамны дэмжлэгтэйгээр, Ази Номхон Далайн Цахилгаан Холбооны Байгууллага (АРТ) -ын хөрөнгө оруулалт болон Япон улсын KDDI сангийн санхүүжилтээр “Монгол улсын нутаг дэвсгэрт Онцгой байдал, Гамшгийн үед мэдээ, мэдээллийг ФМ радио долгионыг ашиглан алс хязгаар бүс нутагт зарлан мэдээлэх” АРТ-С2 төслийг Радио телевизийн үндэсний сүлжээ, Онцгой байдлын ерөнхий газар болон Байгаль орчин, аялал жуулчлалын яамтай хамтран амжилттай хийж гүйцэтгэлээ.</p> <p> 5. МТС Сервис ХХК-ийн үйл ажиллагааг өргөжүүлэх ажлын хүрээнд Амарди ХХК-тай хамтран даатгалын зуучлалын үйлчилгээг 18 аймгийн холбооны газарт нэвтрүүлж эхэллээ. Мөн VPS серверийн түрээс үйлчилгээг Whizzo Tech ХХК-д үзүүлж байна.</p> <p> 6. FTTH төслийн хүрээнд 7 аймгийн 9 суманд гуравласан үйлчилгээ нэвтрүүлээ.</p> <p>Хоёр. Техник технологийн шинэчлэл</p> <p>1. 19 аймгийн Cisco-ASR903 router, PPPoE серверийг Mikrotik CCR1036-8G-2S+ router-д шилжүүлэн төхөөрөмжүүдийг шинэчилснээр 10G холболтоор үйлчилгээг хүргэж эхэллээ.</p> <p>2. Инженер техникийн ажилчдын дотоод нөөц бололцоогоор хөргөлт агааржуулалтын системийг хямд өртгөөр шийдвэрлэх техникийн шийдлийг боловсруулан халуун</p>		

		<p>агаарыг гадагшлуулж, гаднаас хүйтэн агаар сорж оруулах агааржуулалтын системийг шинээр нэвтрүүлээ.</p> <p>3. Telecommongolia.mn цахим хуудсын онлайн салбар цэс, хэрэглэгчийн хөтчийг шинэчлэн хэрэглэгч хялбараар төлбөр төлөх, дугаар захиалах, бүтээгдэхүүн үйлчилгээний захиалга өгөх, бүтээгдэхүүн үйлчилгээний мэдээ, үнэ тариф, урамшууллын мэдээлэл, тусламж заавар, компанийн мэдээлэл харах, оруулах боломж бүрдэн сүүлийн үеийн загвар дизайны шийдлээр шинэчлэлээ.</p> <p>4. OTT системийн транскодерийн шинэчлэл хийснээр OTT үйлчилгээний дүрсний гаралтын чанар, нягтралт сайжран тоон сувгийн урсгал 30% буурсан. Мөн орон нутгийн сувгийг нэмж сувгийн тоог нэмэгдүүлэх боломжтой боллоо.</p>
2.4.	Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлого	
2.5.	Тайлант хугацаанд авсан зээлийн эргэн төлөлт болон зээлийн барьцаа, баталгааны талаарх мэдээлэл	Тайлант хугацаанд зээлийн эргэн төлөлт болон зээлийн барьцаа, баталгаа үүсгэсэн ажил гүйлгээ хийгээгүй.
3.	Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй хэлцэл болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийгдэх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/	
		Тайлант хугацаанд сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцэл хийгдээгүй
4.	Цалин урамшууллын мэдээлэл	
		Компанийн ТУЗ-ийн гишүүдийн хувьд 2024.4.30 хүртэлх 12 сарын хугацаанд Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас баталсан ТУЗ-ийн зардлын төсөв, төлөвлөгөөнд тусгагдсан цалин урамшууллын авсан. Компанийн Гүйцэтгэх удирдлагын хувьд ТУЗ-тай байгуулсан гэрээний дагуу цалин авсан бөгөөд, ТУЗ-өөс 2023 оны Гүйцэтгэх захирлын урамшууллын талаар хэлэлцээд урамшуулал олгохгүй байхаар шийдвэрлэсэн байна.
5.	Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл	
	<p>ЗАСАГЛАЛЫН БҮТЭЦ</p>  <p>Хувьцаа эзэмшигчдийн бүтэц Монголын цахилгаан холбоо ХК-ийн нийт хувьцааны 94.7 хувь буюу 24,499,286 ширхэг хувьцааг Монгол Улсын Засгийн газар, 5.3 хувь буюу 1,370,989 ширхэг хувьцааг Монгол Улсын болон гадаадын иргэн, хуулийн этгээд тус тус эзэмшиж байна.</p>	

Хувьцаа эзэмшигчид



ХУВЬЦААНЫ ТОО

25,870,276

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД

4,008

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН ХУРАЛ

2023 оны эхний хагас жилийн байдлаар Монголын цахилгана холбоо ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хоёр хурлын хуралдууллаа.

Хурлын нэр: Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал

Монголын цахилгаан холбоо ХК-ийн 2023 оны 02 дугаар сарын 15-ны өдөр Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг хуралдууллаа. Хурлын ирц 24,500,292 ширхэг саналын эрх бүхий 7 хувьцаа эзэмшигч оролцсоноор 94.70441 хувьтай байлаа.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар хэлэлцсэн асуудлууд

1. Нэмж гаргах хувьцааны тоо хэмжээ, нэгж үнийг тогтоох тухай
2. Нэмж гаргах хувьцааг одоогийн хувьцаа эзэмшигч хувь хүн, хуулийн этгээдэд тэргүүн ээлжид худалдан авах давуу эрх олгох эсэх тухай

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаас гаргасан шийдвэрүүд

1. Нэмж гаргах хувьцааны тоо хэмжээ, нэгж үнийг тогтоох тухай асуудлыг 100 хувийн саналаар батлав. Үүнд:
 - Компанийн энгийн хувьцааг нэмж гаргахыг зөвшөөрөв.
 - Компанийн нэмж гаргах энгийн хувьцааны тоо ширхэг, нэгж үнийг компанийн 2022 оны санхүүгийн аудитлагдсан тайланд үндэслэн хууль, тогтоомжид нийцүүлэн тогтоож, саналаа Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэхийг Төлөөлөн удирдах зөвлөл (Т.Лхагвасүрэн)-д даалгав.
2. Нэмж гаргах хувьцааг одоогийн хувьцаа эзэмшигч хувь хүн, хуулийн этгээдэд тэргүүн ээлжид худалдан авах давуу эрх олгох эсэх тухай асуудлыг 100 хувийн саналаар батлав. Үүнд:
 - Компанийн хувьцааг эзэмшиж буй хувь хүн, хуулийн этгээдэд нэмж гаргаж буй хувьцааг тэргүүн ээлжид худалдан авах эрхийг хэрэгжүүлэхээр шийдвэрлэв.
 - Нэмж гаргаж буй энгийн хувьцааны нэгж үнийг тогтоосны дараа хувьцаа эзэмшигч бүрийн худалдан авч болох хувьцааны тоо, төлбөр хийх хугацаа, журам зэргийг заасан мэдэгдлийг хувьцаа эзэмшигч бүрт хүргүүлэх ажлыг холбогдох хууль, “Хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-ын дагуу зохион байгуулахыг Төлөөлөн удирдах зөвлөл (Т.Лхагвасүрэн)-д үүрэг болгов.

Хурлын нэр: 2023 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал

Монголын цахилгаан холбоо ХК-ийн 2023 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2023 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн 11:00-14:10 цагт танхимаар болон зайнаас зохион байгуулагдав (Zoom ID: 249 198 1234) URL: telecommon Mongolia.mn/news/shm2022.

2023 оны 4 дүгээр сарын 09-ний өдрөөр тасалбар болгон бүртгэсэн 25,870,276 ширхэг хувьцаа эзэмшиж буй 4,008 хувьцаа эзэмшигчдээс 24,501,420 ширхэг саналын эрх бүхий 18 хувьцаа эзэмшигч оролцож ирц 94.71 хувьтай байлаа. Хурлын даргаар МЦХ ХК-ийн Маркетинг борлуулалтын газрын захирал Содномдовжидын Нямбаяр, хурал зохион байгуулах комиссын даргаар Удирдлага хүний нөөцийн газрын захирал Ч.Цогтгэрэл, гишүүдээр ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Х.Цэцэгмаа, Хууль, гадаад харилцааны албаны ерөнхий менежер

Ж.Азбаяр нар тус тус ажиллаа.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцсэн асуудлууд

1. Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлах тухай;
2. Компанийн 2022 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлтийг батлах тухай;
3. Төлөөлөн удирдах зөвлөлийн Аудитын хорооны санхүүгийн тайлангийн талаарх дүгнэлтийг батлах тухай;
4. 2021 оны ногдол ашиг тараасан тайлан танилцуулах тухай;
5. 2022 оны ногдол ашиг хуваарилахгүй гэж шийдвэрлэсэн Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоол, үндэслэлийг танилцуулах тухай
6. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг чөлөөлж, сонгох тухай;
7. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны зардлын төсвийг батлах тухай

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас гаргасан шийдвэрүүд

1. Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлах тухай асуудлыг 100 хувийн саналаар батлав.
2. Компанийн 2022 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлтийг батлах тухай асуудлыг 100 хувийн саналаар баталж, Монголын цахилгаан холбоо ХК-ийн хараат бус аудитын байгууллагаар хийлгэсэн аудитын тайлан, дүгнэлтийг зөвшөөрөв.
3. Төлөөлөн удирдах зөвлөлийн Аудитын хорооны санхүүгийн тайлангийн талаарх дүгнэлтийг батлах тухай асуудлыг 99.99 хувиар батлав.
 - a. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг чөлөөлж, сонгох тухай асуудалд кумулятив аргаар хамгийн олон хувьцааны санал авсан С.Цолмон, Ц.Норовжамц, Х.Баянбай нарыг Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр тус тус сонгов. Ж.Тамир, Ю.Бат-Эрдэнэ нарыг Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүний үүрэгт ажлаас 2023 оны 4 дүгээр сарын 28-ны өдрөөр тасалбар болгон тус тус чөлөөлж, бүрэн эрхийг нь дуусгавар болгов.
4. ТУЗ-ийн 2023 оны зардлын төсвийг батлах тухай асуудлыг 100 хувийн саналаар батлав.

Хурлын нэр: Монголын цахилгаан холбоо ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал

2023 оны 10 дугаар сарын 09-ний өдөр 11:00-13:00 цагт Чингэлтэй дүүрэг, Энхтайваны өргөн чөлөө 1, Төв шуудангийн байр, 4 давхрын “Мэдээлэл холбооны сүлжээ” ХХК-ийн хурлын зааланд хуралдав. Хурлын дарга Содномдовжидын Нямбаяр, Тооллогын комиссын дарга С.Цог, гишүүд Т.Бямбасүрэн, Б.Жулан. Хурал зохион байгуулах комиссын дарга Ч.Цогтгэрэл, гишүүд Х.Цэцэгмаа, Ж.Азбаяр нар тус тус ажиллаа. Хурлын ирц: 94.70% (24,500,087 ширхэг хувьцааны саналын эрх)

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар хэлэлцсэн асуудлууд:

1. Компанийн хувьцааг нэмж гаргах, олон нийтэд санал болгох тухай, үүнд:
 - Компанийн зарласан хувьцааны тоог нэмэгдүүлэх тухай;
 - Зарласан хувьцааны тоонд багтаан хувьцаа нэмж гаргах тухай, нэмж гаргасан хувьцааг олон нийтэд санал болгох тухай;
 - Олон нийтэд нээлттэй санал болгох хувьцааны тоо ширхгийг тогтоох тухай;
 - Нэмж гаргах хувьцааны олон нийтэд санал болгох зах зээлийн үнийг хараат бус бизнесийн үнэлгээний тайланд үндэслэн тогтоох бүрэн эрхийг Төлөөлөн удирдах зөвлөлд олгох тухай;
 - Компанийн одоогийн хувьцаа эзэмшигчдийн нэмж гаргах хувьцаанаас тэргүүн ээлжид худалдан авах давуу эрхийг хэрэгжүүлэх эсэх тухай;
 - Анхдагч зах зээлд хувьцааны захиалгын хэмжээ давж биелсэн тохиолдолд нийтэд санал болгон гаргасан хувьцааны хэдэн хувьтай тэнцэх хэмжээний хувьцааг нэмж гаргахыг тогтоох тухай;
 - Компанийн одоогийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигч болон стратегийн хөрөнгө

- оруулагч нь хувьцааны хоёрдогч зах зээлийн арилжаа нээгдсэнээс хойш 6 сарын хугацаанд хувьцаагаа арилжаалахгүй байх буюу тусгаарлуулах үүрэг хүлээх тухай;
- Олон нийтэд хувьцаа нэмж гаргахтай холбоотой шийдвэрийн биелэлтийг хангаж ажиллах, Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн биржид хувьцаагаа бүртгүүлэхэд шаардлагатай бүх талын арга хэмжээг авч ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлд даалгах тухай;
 - Хувьцаа нэмж гарган, олон нийтэд санал болгохтой холбоотой бусад асуудлыг тухай бүр хэлэлцэн шийдвэрлэх бүрэн эрхийг Төлөөлөн удирдах зөвлөлд олгох тухай;
 - Нэмж гаргасан хувьцааг зах зээлд нээлттэй арилжаалахыг Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн биржээс зөвшөөрсөн хүрээнд хувьцааны анхдагч зах зээлийн арилжаа амжилттай болсны дараа зохион байгуулах Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх Компанийн “Дүрмийн төсөл”-ийг танилцуулах тухай;
2. 2023 оны 2 дугаар сарын 15-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын 02 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцох тухай;
3. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгох тухай;

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаас гаргасан шийдвэрүүд:

1. Компанийн хувьцааг нэмж гаргах, олон нийтэд санал болгох тухай асуудлыг 100 хувийн саналаар батлав. Үүнд:
- Компанийн зарласан болон гаргасан энгийн хувьцааны тоо нийт 25,870,276 (хорин таван сая найман зуун далан мянга хоёр зуун далан зургаа) ширхэг болохыг дурдав.
 - Компанийн зарласан энгийн хувьцааны тоог нийт 37,120,131 (гучин долоон сая нэг зуун хорин мянга нэг зуун гучин нэг) ширхэг болгон нэмэгдүүлэв.
 - Компанийн одоогийн гаргасан 25,870,276 (хорин таван сая найман зуун далан мянга хоёр зуун далан зургаа) ширхэг энгийн хувьцаа дээр нэмж, зарласан энгийн хувьцаанаас нэг бүр нь 100 (нэг зуу) төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 11,249,855 (арван нэгэн сая хоёр зуун дөчин есөн мянга найман зуун тавин тав) ширхэг энгийн хувьцааг нийтэд санал болгон нээлттэй арилжаалахаар нэмж гаргав.
 - Энэхүү шийдвэрийн дагуу нэмж гаргаж буй 11,249,855 (арван нэгэн сая хоёр зуун дөчин есөн мянга найман зуун тавин тав) ширхэг энгийн хувьцаа нь Компанийн нийт гаргасан 37,120,131 (гучин долоон сая нэг зуун хорин мянга нэг зуун гучин нэг) ширхэг энгийн хувьцааны 30.31 хувьтай тэнцэх бөгөөд нэмж гаргах хувьцааны олон нийтэд санал болгох зах зээлийн үнийг хараат бус бизнесийн үнэлгээний тайланг үндэслэн тогтоох эрхийг Төлөөлөн удирдах зөвлөлд олгов.
 - Монгол Улсын Их Хурлын 2022 оны 16 дугаар тогтоол, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 244 дүгээр тогтоолоор нэмж гаргасан хувьцааг олон нийтэд санал болгохоор шийдвэрлэсэн зарчмыг баримтлан компанийн одоогийн хувьцаа эзэмшигч нь нэмж гаргасан хувьцааг тэргүүн ээлжид худалдан авах эрхийг хэрэгжүүлэхгүй байхаар шийдвэрлэв.
 - Анхдагч зах зээлд хувьцааны захиалгын хэмжээ давж биелсэн тохиолдолд нэмж хувьцаа гаргахгүй байхаар тогтов.
 - Компанийн нийт хувьцааны 5 буюу түүнээс дээш хувийг дангаар болон нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигч болон стратегийн хөрөнгө оруулагч нь хувьцааны хоёрдогч зах зээлийн арилжаа нээгдсэнээс хойш 6 (зургаа) сарын хугацаанд Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллага дээр тусгаарлуулж, арилжаанд оруулахгүй байх үүрэг хүлээх нөхцөлтэй болохыг дурдав.
 - Олон нийтэд хувьцаа нэмж гаргахтай холбоотой шийдвэрийн биелэлтийг хангаж ажиллах, Санхүүгийн зохицуулах хороо, “Монголын хөрөнгийн бирж” ХК-д хувьцаагаа бүртгүүлэхэд шаардлагатай бүх талын зохион байгуулалтын арга хэмжээг авч ажиллах, хувьцаа нэмж гаргасны дараах хувьцаа эзэмшигчдийн хуралд тайланг танилцуулахыг Төлөөлөн удирдах зөвлөлд даалгаж, холбогдох гэрээ хэлцэл байгуулах баримт бичгүүдэд гарын үсэг зурах бүрэн эрхийг Төлөөлөн удирдах зөвлөл (Ц.Баяр-Эрдэнэ)-д олгов.
 - Нэмж хувьцаа гарган, олон нийтэд санал болгохтой холбоотой компанийн дүрэм, энэхүү тогтоолд тухайлан заагаагүй бусад асуудлыг тухай бүр хэлэлцэн шийдвэрлэх бүрэн эрхийг Төлөөлөн удирдах зөвлөлд олгов.

- Нэмж гаргасан хувьцааг олон нийтэд санал болгох, хувьцааг зах зээлд нээлттэй арилжаалахыг Санхүүгийн зохицуулах хороо, “Монголын хөрөнгийн бирж” ХК-иас зөвшөөрсний хүрээнд хувьцааны анхдагч арилжаа амжилттай болсны дараа зохион байгуулах Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх Компанийн “Дүрмийн төсөл”-ийг хавсралтаар батлав.

- Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлд даалгав.

2. 2023 оны 2 дугаар сарын 15-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын 02 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцох тухай асуудлыг 100 хувийн саналаар батлав. Үүнд:

- Компанийн одоогийн хувьцаа эзэмшигчид нь нэмж гаргасан хувьцааг тэргүүн ээлжид худалдан авах эрхийг хэрэгжүүлэхгүй байхаар шийдвэрлэсэнтэй холбогдуулан 2023 оны 2 дугаар сарын 15-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 02 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцов.

- Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлд даалгав.

3. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгох тухай асуудалд кумулятив аргаар хамгийн олон хувьцааны санал авсан нэр дэвшигчдийг Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнээр сонгов.

- Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ерийн гишүүнээр Б.Төрбат, Ц.Баяр-Эрдэнэ нарыг сонгов.

- Т.Лхагвасүрэн, Г.Эрдэнэбулган нарыг Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний үүрэгт ажлаас чөлөөлж, бүрэн эрхийг нь дуусгавар болгов.

- Компанийн үйл ажиллагааг үр ашигтай удирдан зохион байгуулж, холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмын дагуу ажиллахыг сонгогдсон Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд үүрэг болгов.

Хурлын нэр: 2024 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал

2024 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр 11:00-14:20 цагт Мэдээлэл холбооны сүлжээ ТӨХХК-ийн хурлын зааланд хуралдав. Хурлын дарга Жанчивдоржийн Баасандорж, тооллогын комиссын дарга С.Цог, гишүүд Т.Бямбасүрэн, Э.Булганчимэг, хурал зохион байгуулах комиссын дарга Ч.Цогтгэрэл, гишүүд: Х.Цэцэгмаа, Ж.Азбаяр. Хурлын ирц: Компанийн нийт гаргасан хувьцааны тоо 25,870,276 ширхэг. Үүнээс нийт 24,501,004 ширхэг саналын эрх бүхий 18 хувьцаа эзэмшигч оролцож ирц 94.71% байв.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцсэн асуудлууд:

1. Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг танилцуулах, тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлах тухай;
2. Компанийн 2023 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын тайланг батлах тухай;
3. Төлөөлөн удирдах зөвлөлийн Аудитын хорооны санхүүгийн тайлангийн талаарх дүгнэлтийг батлах тухай;
4. 2023 оны ногдол ашиг хуваарилахгүй гэж шийдвэрлэсэн Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоол, үндэслэлийг танилцуулах тухай
5. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг чөлөөлж, сонгох тухай;
6. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны үйл ажиллагааны тайлан, 2024 оны зардлын төсвийг батлах тухай;

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас гаргасан шийдвэрүүд:

1. Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг танилцуулах, тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлах тухай асуудлыг 100 хувийн саналаар батлав.

- Монголын цахилгаан холбоо ХК-ийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг тус тус зөвшөөрч батлав.

2. Компанийн 2023 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын тайланг

батлах тухай асуудлыг 100 хувийн саналаар батлав.

- Монголын цахилгаан холбоо ХК-ийн 2023 оны санхүүгийн тайлан тэнцлийг дор дурдсанаар батлав:

о Нийт хөрөнгийг 68,015,906,822.96 (Жаран найман тэрбум арван таван сая есөн зуун зургаан мянга найман зуун хорин хоёр төгрөг ерэн зургаан мөнгө), үүнээс эргэлтийн бус хөрөнгийг 54,206,606,900.44 (Тавин дөрвөн тэрбум хоёр зуун зургаан сая зургаан зуун зургаан мянга есөн зуун төгрөг дөчин дөрвөн мөнгө) -өөр;

о Өр төлбөрийн нийт дүнг 17,648,166,597.73 (Арван долоон тэрбум зургаан зуун дөчин найман сая нэг зуун жаран зургаан мянга таван зуун ерэн долоон төгрөг далан гурван мөнгө) -өөр;

о Эзэмшигчийн өмчийг 50,367,740,225.23 (Тавин тэрбум гурван зуун жаран долоон сая долоон зуун дөчин мянга хоёр зуун хорин таван төгрөг хорин гурван мөнгө) -өөр

- Монголын цахилгаан холбоо ХК-ийн хараат бус аудитын хуулийн этгээдийн хийлгэсэн аудитын тайлан, дүгнэлтийг зөвшөөрөв.

3. Төлөөлөн удирдах зөвлөлийн Аудитын хорооны санхүүгийн тайлангийн талаарх дүгнэлтийг батлах тухай асуудлыг 100 хувийн саналаар батлав.

- Монголын цахилгаан холбоо ХК-ийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн Төлөөлөн удирдах зөвлөлийн Аудитын хорооны дүгнэлтийг зөвшөөрч батлав.

4. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг чөлөөлж, сонгох тухай асуудалд кумулятив аргаар хамгийн олон хувьцааны санал авсан нэр дэвшигчдийг Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр сонгов.

- Монголын цахилгаан холбоо ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд нэр дэвшигчдээс кумулятив аргаар хамгийн олон санал авсан С.Цолмон, Х.Баянбай, Ц.Норовжамц нарыг Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр, Д.Нарангэрэл, Б.Билэгдэмбэрэл, С.Ганзориг, А.Молор, Б.Төрбат, Ц.Баяр-Эрдэнэ нарыг Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнээр 2024 оны 4 дүгээр сарын 30-ны өдрөөс тус тус сонгов.

- Ж.Цогтбаяр, Ч.Цэвэгдорж, М.Лхагважав нарыг Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүний үүрэгт ажлаас 2024 оны 4 дүгээр сарын 30-ны өдрөөр тасалбар болгон тус тус чөлөөлж, бүрэн эрхийг нь дуусгавар болгов.

- Компанийн үйл ажиллагааг үр ашигтай удирдан зохион байгуулж, холбогдох хууль, дүрэм, журмын дагуу ажиллахыг сонгогдсон Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд үүрэг болгов.

5. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны үйл ажиллагааны тайлан, 2024 оны зардлын төсвийг батлах тухай асуудлыг 100 хувийн саналаар батлав.

- Монголын цахилгаан холбоо ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны зардлын төсвийг хавсралтаар батлав.

- Батлагдсан төсвийн зарцуулалтад хяналт тавьж, зардал хэтрүүлэхгүй, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалинг түүний ажлын үр дүнг харгалзан олгож байхыг Төлөөлөн удирдах зөвлөлийн даргад үүрэг болгов.

ТУЗ-ийн бүрэлдэхүүн

Монголын цахилгаан холбоо ХК-ийн 2024 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг чөлөөлж, сонгосон. Төлөөлөн удирдах зөвлөл нь 2024 оны 5 сарын 31-ний байдлаар дараах бүрэлдэхүүнтэй ажиллаж байна. Үүнд:

ТУЗ-ийн ДАРГА



Ц.БАЯР-ЭРДЭНЭ
Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн дарга

ЕРДИЙН ГИШҮҮД








Б.ТӨРБАТ
ЗГ-ийн хэрэг эрхлэх газар, Хууль, эрхзүйн газар, шинжээч



Б.БИЛЭГДЭМБЭРЭЛ
ЦХХХЯ-ны Цахим хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, Мэдээллийн

	<p style="text-align: right;">технологийн зөвлөх инженер</p> <div style="display: flex; justify-content: space-around;"> <div style="text-align: center;">  А.МОЛОР Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс, мэргэжилтэн </div> <div style="text-align: center;">  Д.НАРАНГЭРЭЛ Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтсийн дарга, Мэргэшсэн нягтлан бодогч </div> <div style="text-align: center;">  С.ГАНЗОРИГ ЦХХХЯ-ны Салбарын хяналтын газрын дарга </div> </div> <p style="text-align: center;">ХАРААТ БУС ГИШҮҮД</p> <div style="display: flex; justify-content: space-around;"> <div style="text-align: center;">  Ц.НОРОВЖАМЦ Интер аудит ХХК-ийн гэрээт аудитор </div> <div style="text-align: center;">  Х.БАЯНБАЙ Акпар-Аудит компанийн Ерөнхий захирал </div> <div style="text-align: center;">  С.ЦОЛМОН Мандах их сургуулийн Ахисан түвшний сургуулийн захирал </div> </div>						
6.	<p><i>Зах зээлийн эрсдэлийн мэдээлэл</i></p> <p>Компани нь ТУЗ-ийн 2023 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн 190 дүгээр хурлын 01 тоот тогтоолоор “Эрсдэлийн удирдлагын журам”-ыг баталсан бөгөөд мөн ТУЗ-ийн 2023 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 196 дугаар хурлын 03 тоот тогтоолоор журмыг шинэчлэн баталсан. Эрсдэлийг илрүүлэх, эрсдэлийг шинжлэх, эрсдэлийг үнэлж, дүгнэх гэсэн үе шаттайгаар эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлдэг.</p> <p>Хэрэглэгчийн цахим хэрэглээ нэмэгдэж байгаа нь салбарын өрсөлдөөн нэмэгдэх, зах зээлд шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг дэвшилтэт технологиор хүргэх нь томоохон сорилт болж байна. Өрсөлдөгч компаниуд зах зээлд дэвшилтэт технологи нэвтрүүлж хэрэглэгчид шинэлэг бүтээгдэхүүн, үйлчилгээг санал болгох нь хэрэглэгчийн тоо буурах, зорилтот түвшинд борлуулалт буурах зэрэг зах зээлийн эрсдэл үүсгэж байна.</p> <p>Компани хэрэглэгчийн тоог нэмэх, хэрэглэгчийн эрэлт хэрэгцээнд нийцсэн бүтээгдэхүүн үйлчилгээг зах зээлд нэвтрүүлэхийг эрмэлзэж ажилладаг бөгөөд жил бүр үйлчилгээ болон техник, технологийн өргөтгөл хийж, хэрэглэгчид шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ, төлбөрийн уян хатан нөхцөл санал болгон ажиллаж байна. Түүнчлэн Дунд хугацааны бизнес төлөвлөлтийн дагуу жил бүр тоног төхөөрөмжийн тодорхой үе шатны дагуу шинэчлэхээр төлөвлөж байна.</p> <p>Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • 2023 – 2028 онд суурин интернэтийн GPON өргөтгөлөөс XGPON өргөтгөл рүү шилжих; • 2023 – 2027 онд суурин утасны NGN холболтыг IMS технологи руу шилжүүлэх; • 2023 – 2027 онд төлбөр тооцооны нэгдсэн системийн шинэчлэл; • 2023 – 2028 онд IPv4-IPv6 системийн шинэчлэл; • 2024 – 2026 онд LTE буюу утасгүй өргөн зурвасын сүлжээ байгуулах; • 2024 – 2025 онд суурин утсанд SMS үйлчилгээг нэвтрүүлэх; • 2024 – 2027 онд TV Room контент үйлчилгээг нэвтрүүлэх; • 2024 – 2026 онд Өргөн зурвасын өндөр хурдны гуравласан үйлчилгээний /FTTH/ технологийн багтаамжийг нэмэгдүүлж, үндсэн ба дэд сүлжээг өргөтгөх. 						
7.	<p><i>Хувьцаа эзэмшигчдийн өмчлөлийн мэдээлэл /5 ба түүнээс дээш хувьцаа эзэмшигчдийн нэрс, эзэмшлийн хувь, нийт хувьцаа эзэмшигчдийн тоо/</i></p>						
	<table border="1"> <thead> <tr> <th>Хувьцаа эзэмшигчийн нэр</th> <th>Тоо</th> <th>Хувь эзэмшлийн хэмжээ</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>ТӨБЗГ</td> <td>24.499.287</td> <td>94.70%</td> </tr> </tbody> </table>	Хувьцаа эзэмшигчийн нэр	Тоо	Хувь эзэмшлийн хэмжээ	ТӨБЗГ	24.499.287	94.70%
Хувьцаа эзэмшигчийн нэр	Тоо	Хувь эзэмшлийн хэмжээ					
ТӨБЗГ	24.499.287	94.70%					

<p style="text-align: center;">Хувьцаа эзэмшлийн хувь</p>  <p style="text-align: center;">■ ТӨБЗГ ■ Бусад</p>	<table border="1"> <tr><td>ДААМАЙ ИНВЕСТ ХХК</td><td>9.673</td><td>0.04%</td></tr> <tr><td>БИДИСЕК ҮЦК ХК</td><td>13.929</td><td>0.05%</td></tr> <tr><td>ТӨРИЙН БАНК ХХК</td><td>16.035</td><td>0.06%</td></tr> <tr><td>МОНГОЛ ДААТГАЛ ХК</td><td>29.807</td><td>0.12%</td></tr> <tr><td>Д.БЕЙБИТ</td><td>542.456</td><td>2.10%</td></tr> <tr><td>ALEXANDER ZWAHR</td><td>52.315</td><td>0.20%</td></tr> <tr><td>POLUNIN DOUGLAS</td><td>26.627</td><td>0.10%</td></tr> <tr><td>П.ЧИМГЭЭ</td><td>26.539</td><td>0.10%</td></tr> <tr><td>YUJIRO KOYANAGI</td><td>23.029</td><td>0.09%</td></tr> <tr><td>Л.ГҮНДЭГМАА</td><td>19.243</td><td>0.07%</td></tr> <tr><td>THOMAS EUGEN</td><td>15.092</td><td>0.06%</td></tr> <tr><td>Э.ЭНХСАЙХАН</td><td>15.053</td><td>0.06%</td></tr> <tr><td>Б.АМГАЛАНБААТАР</td><td>14.976</td><td>0.06%</td></tr> <tr><td>PHILLIPS MARK</td><td>14.091</td><td>0.05%</td></tr> <tr><td>Л.ЧУЛУУНБААТАР</td><td>10.015</td><td>0.04%</td></tr> <tr><td>Бусад хувьцаа эзэмшигч</td><td>542.109</td><td>2.10%</td></tr> <tr><td>Нийг дүн</td><td>25,870,276</td><td>100.00%</td></tr> <tr><td>Хувьцаа эзэмшигчийн тоо</td><td>4,006</td><td></td></tr> </table>	ДААМАЙ ИНВЕСТ ХХК	9.673	0.04%	БИДИСЕК ҮЦК ХК	13.929	0.05%	ТӨРИЙН БАНК ХХК	16.035	0.06%	МОНГОЛ ДААТГАЛ ХК	29.807	0.12%	Д.БЕЙБИТ	542.456	2.10%	ALEXANDER ZWAHR	52.315	0.20%	POLUNIN DOUGLAS	26.627	0.10%	П.ЧИМГЭЭ	26.539	0.10%	YUJIRO KOYANAGI	23.029	0.09%	Л.ГҮНДЭГМАА	19.243	0.07%	THOMAS EUGEN	15.092	0.06%	Э.ЭНХСАЙХАН	15.053	0.06%	Б.АМГАЛАНБААТАР	14.976	0.06%	PHILLIPS MARK	14.091	0.05%	Л.ЧУЛУУНБААТАР	10.015	0.04%	Бусад хувьцаа эзэмшигч	542.109	2.10%	Нийг дүн	25,870,276	100.00%	Хувьцаа эзэмшигчийн тоо	4,006	
ДААМАЙ ИНВЕСТ ХХК	9.673	0.04%																																																					
БИДИСЕК ҮЦК ХК	13.929	0.05%																																																					
ТӨРИЙН БАНК ХХК	16.035	0.06%																																																					
МОНГОЛ ДААТГАЛ ХК	29.807	0.12%																																																					
Д.БЕЙБИТ	542.456	2.10%																																																					
ALEXANDER ZWAHR	52.315	0.20%																																																					
POLUNIN DOUGLAS	26.627	0.10%																																																					
П.ЧИМГЭЭ	26.539	0.10%																																																					
YUJIRO KOYANAGI	23.029	0.09%																																																					
Л.ГҮНДЭГМАА	19.243	0.07%																																																					
THOMAS EUGEN	15.092	0.06%																																																					
Э.ЭНХСАЙХАН	15.053	0.06%																																																					
Б.АМГАЛАНБААТАР	14.976	0.06%																																																					
PHILLIPS MARK	14.091	0.05%																																																					
Л.ЧУЛУУНБААТАР	10.015	0.04%																																																					
Бусад хувьцаа эзэмшигч	542.109	2.10%																																																					
Нийг дүн	25,870,276	100.00%																																																					
Хувьцаа эзэмшигчийн тоо	4,006																																																						
<table border="1"> <thead> <tr> <th>Хувьцаа эзэмшигчийн нэр</th> <th>Хувьцаа тоо</th> <th>Хувьцаа эзэмшигч тоо</th> <th>Хувьцаа эзэмшил хувь</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>ТӨБЗГ</td> <td>24,499,287</td> <td>1</td> <td>94.70%</td> </tr> <tr> <td>Хуулийн этгээд</td> <td>83,830</td> <td>23</td> <td>0.32%</td> </tr> <tr> <td>Гадаад иргэн</td> <td>165,093</td> <td>65</td> <td>0.64%</td> </tr> <tr> <td>Дотоод иргэн</td> <td>1,122,066</td> <td>3917</td> <td>4.34%</td> </tr> <tr> <td>Нийт</td> <td>25,870,276</td> <td>4006</td> <td>100.00%</td> </tr> </tbody> </table>	Хувьцаа эзэмшигчийн нэр	Хувьцаа тоо	Хувьцаа эзэмшигч тоо	Хувьцаа эзэмшил хувь	ТӨБЗГ	24,499,287	1	94.70%	Хуулийн этгээд	83,830	23	0.32%	Гадаад иргэн	165,093	65	0.64%	Дотоод иргэн	1,122,066	3917	4.34%	Нийт	25,870,276	4006	100.00%																															
Хувьцаа эзэмшигчийн нэр	Хувьцаа тоо	Хувьцаа эзэмшигч тоо	Хувьцаа эзэмшил хувь																																																				
ТӨБЗГ	24,499,287	1	94.70%																																																				
Хуулийн этгээд	83,830	23	0.32%																																																				
Гадаад иргэн	165,093	65	0.64%																																																				
Дотоод иргэн	1,122,066	3917	4.34%																																																				
Нийт	25,870,276	4006	100.00%																																																				
8.	<p><i>Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойш дуусах хүртэл хугацаанд төслийн хэрэгжилтийн явц болон татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан мэдээлэл</i></p>																																																						
	<p>ГРО гаргах ажил</p> <ul style="list-style-type: none"> Санхүүгийн зохицуулах хороонд бүртгэлтэй андеррайтер, хууль, аудитын үйлчилгээ үзүүлэгч болон хөрөнгийн үнэлгээний үйлчилгээ үзүүлэгч хуулийн этгээдийг сонгон шалгаруулах түр журмыг тус компанийн ТУЗ-ийн 191-р хурлын 2-р тогтоолоор баталсан Андеррайтерийн зөвлөх үйлчилгээ үзүүлэгчээр Ти Ди Би секьюритис ҮЦК ХХК, Аудитын зөвлөх үйлчилгээ үзүүлэгчээр Өлзийт экаунт аудит ХХК, Үнэлгээний үйлчилгээ үзүүлэгчээр Мөнх-Оргил трейд үнэлгээ ХХК, хуулийн зөвлөхийн үйлчилгээ үзүүлэгчээр Соёмбо легал партнерс ХХН-тэй тус тус зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулсан Монголын цахилгаан холбоо ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зохион байгуулж, нэмэлт хувьцааг нийтэд санал болгон биржид бүртгүүлж, нээлттэй арилжаалахтай холбоотой багц асуудлыг шийдвэрлэсэн Зөвлөх үйлчилгээ үзүүлэгчид нь гэрээнд заасан хугацаанд холбогдох дүгнэлтүүдээ эцэслэн гаргаж бидэнд ирүүлсэн бөгөөд МЦХ ХК-ийн Үнэт цаасны танилцуулгыг бэлтгэн тус компанийн ТУЗ-ийн хуралд 2023 оны 197-р хурлаар танилцуулж, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 56-р зүйлийн 56.2.1 дэх заалтад заасны дагуу холбогдох шийдвэр гаргуулахаар ТӨБЗГ-т хүргүүлэн холбогдох арга хэмжээ авч МЦХ ХК-ийн ТУЗ-ийн 2023 оны 198-р хурлаар үнэт цаасны танилцуулга, арилжааны журмыг батлуулав. ТУЗ санал болгох үнэ, үнэт цаасны танилцуулга, арилжааны журмыг эцэслэн баталж, хууль, журмын дагуу Монголын хөрөнгийн бирж ХК, Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлсэн. “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгчийн А/14 тоот тушаалаар МЦХ ХК-ийн нэмж гаргаж байгаа 11,249,855 ширхэг энгийн хувьцааг МХБ ХК-ийн хувьцааны бүртгэлд бүртгэхээр шийдвэрлэсэн СЗХ нь “Нэмж гаргаж буй үнэт цаасыг нийтэд санал болгохыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэлд бүртгэх тухай” 44 дүгээр тогтоолыг гаргасан. Хөрөнгийн бирж дээр цан цохих ажиллагаа явуулах төлөвлөгөөний дагуу хөрөнгийн 																																																						

	<p>биржтэй гэрээ байгуулах, цан цохих ёслолын хөтөлбөр гаргах ажиллагаа хийгдэж байна.</p> <p>Тайлант хугацаанд олон нийтэд хувьцаа санал болгоогүй болно.</p>
9.	<p><i>Ногдол ашгийн мэдээлэл</i></p> <p>Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 2 дугаар сарын 19 өдрийн 201 дугаар хурлаар 2023 оны цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн.</p>
10.	<p><i>Үнэт цаас гаргагчаас тайланд хугацаанд нийгмийн хариуцлагын чиглэлээр хийгдсэн ажлын тайлангийн мэдээлэл</i></p> <ul style="list-style-type: none"> “Монголын Цахилгаан Холбоо” ХК -ны ажилтан, албан хаагчид эх байгалиа хайрлан хамгаалах, мод тарих үйлсэд бодитой хувь нэмэр оруулж 2023 оны 10 дугаар сарын 07-ны өдөр Баянзүрх дүүргийн 28 дугаар хороонд шинээр байгуулагдаж буй IGM буюу Олон улсын Экологийн цэцэрлэгт хүрээлэнд 50 ширхэг хайлаас мод тариалаа. <div style="display: flex; justify-content: center; gap: 10px;">    </div> <ul style="list-style-type: none"> Нийгмийн хариуцлагын хүрээнд нийслэлийн Сүхбаатар дүүрэг, Сэлэнгэ, Хөвсгөл аймгийн төрийн өмчийн ерөнхий боловсролын сургуулиуд, мөн Улсын 2-р төв эмнэлгийн хүүхдийн тасагт нийт 50ш “Итгэлтэй утас” суурилууллаа.
<p><i>Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо:</i></p>	
<p>Овог, нэр: <i>Баатаржав Чинбат</i></p> <p>Албан тушаал: <i>"МЦХ" ХК-ийн Гүйцэтгэх захирал</i></p> <p>Гарын үсэг:</p>	
<p><i>Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо:</i></p>	
<p>Овог, нэр: <i>Хуягийн Цэцэгмаа</i></p> <p>Албан тушаал: <i>ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга</i></p> <p>Гарын үсэг:</p>	